



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

Дэд салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Монгол Улсын засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/1220 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн хэмжээнд төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг зохион байгуулах дэд салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалт, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Улсын үзлэгт бэлтгэх комиссыг байгууллага бүр дотоодоо байгуулж, үзлэгийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж амжилттай дүгнүүлэх, салбар комисст үзлэг явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг нийт байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Салбар комисс улсын үзлэгийг дүүргийн хэмжээнд батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, улсын үзлэгийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган баталж, дүн, тайланг нэгтгэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн саналыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл хөтөлж, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагын удирдлагад зохих арга хэмжээг төлөвлөж, Нийслэлийн салбар комисст тайлагнаж ажиллахыг дэд салбар комисс (Ж.Тамир)-т даалгасугай.

4.Салбар комиссын нийлбэр дүнгээр амжилттай дүгнэгдсэн ажилтан албан хаагчдыг шагнаж, урамшуулахыг үзлэгт хамрагдсан байгууллагуудын удирдлагад зөвшөөрсүгэй.

5.Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010941